



БАЯНХОНГОР АЙМГИЙН
ГУРВАНБУЛАГ СУМЫН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2023 оны 04 сарын 10 өдөр

Дугаар А/28

Пионер толгой

┌ Малын халдварт өвчнөөс урьдчилан ┐
сэргийлэх дархлаажуулалтын ажлыг
зохион байгуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1, Мал, амьтны эрүүл мэндийн тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.6 дахь заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Малын халдварт өвчнөөс урьдчилан сэргийлэх дархлаажуулалтын ажлыг 04 дүгээр сарын 10-ны өдрөөс 10 дугаар сарын 20-ний хооронд зохион байгуулсугай.

2.Малын халдварт өвчнөөс урьдчилан сэргийлэх дархлаажуулалтын ажлын төлөвлөгөөг хавсралтаар баталсугай.

3.Дархлаажуулалтын ажлыг технологит хугацаанд чанартай зохион байгуулахыг Мал эмнэлгийн тасаг (Э.Хас-Очир), Мал эмнэлгийн аж ахуйн нэгжийн эмч нарт даалгасугай.

4.Дархлаажуулалт хийснээс хойш 28 хоногийн хугацаанд тухайн малчны хотноос мал, малын гаралтай түүхий эд, бүтээгдэхүүнийг хүнсний зориулалтаар хэрэглэх, зах зээлд борлуулах, нөөц бүрдүүлэхийг хориглосугай.

5.Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Засаг даргын орлогч (Э.Сүглэгмаа)-д даалгасугай.

ДАРГА



Б.ГАНТУЛГА

642201259

2023/Засаг дарга/Захирамж2023

Сумын Засаг даргын 2023 оны
...4 дугаар сарын ...10-ны өдрийн
А/37 дугаар захирамжийн хавсралт



МАЛЫН ХАЛДВАРТ ӨВЧНӨӨС УРЬДЧИЛАН СЭРГИЙЛЭХ
ДАРХЛААЖУУЛАЛТЫН АЖЛЫН ТӨЛӨВЛӨГӨӨ

№	Вакцины нэр	Хийгдэх хугацаа
1	Дотрын халдварт хордлого	2023.04.10-2023.05.30
2	Бруцеллёз	2023.08.01-2023.08.30
3	Шөвөг яр	2023.04.10-2023.04.20
4	Галзуу	2023.04.10-2023.05.30
5	Колибактериоз	2023.04.10-2023.05.30
6	Сахуу	2023.07.01-2023.08.30
7	Тугалын иж балнад	2023.07.20-2023.08.20
8	Цусан халдварт	2023.04.10-2023.09.30
9	Боом	2023.04.01-2023.05.30

_____ оОо _____